

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Уул уурхайн сайдын 2013 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус баримтлан Уул уурхайн яамны 2015 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгсөн.

Яамны 2015 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2015 оны Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд уул уурхайн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч /ерөнхий менежер/ тай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, яамны 2015 оны үйл ажиллагааны тайлан, бусад мэдээ материалд тулгуурлан Засгийн газрын 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 4 багц, 13 үзүүлэлтээр дүгнэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2015 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад гүйцэтгэлийн үр дүнгийн ерөнхий үнэлгээ **84,0** хувь буюу **4,2** оноотой дүгнэгдлээ.

I. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ.**1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар 54 зорилтын 127 арга хэмжээг хяналтанд авснаас 18 арга хэмжээг дангаар, 30 арга хэмжээг толгойлон, 79 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба эдгээрийн биелэлтэд 2014 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхайн яамны 2015 онд хэрэгжүүлсэн нийт 127 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний биелэлт 87,78%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 85,33%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 83,73, нийт арга хэмжээний биелэлт 84,71%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/203 тоотор ЗГХЭГ-т хүргүүлж Уул уурхайн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан геологи, уул уурхай, газрын тосны салбарын зорилтуудын 2015 оны жилийн эцсийн хэрэгжилт, түүнд хийсэн үнэлгээний дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан геологи, уул уурхай, газрын тосны салбарын зорилтуудын хэрэгжилтийн явц

(2015 оны жилийн эцэс)

Бодлогын зорилт	Арга хэмжээний тоо	Биелэлтийн явц /хувь/						Тасарсан	Дүгнэгдээгүй	Биелэлт /хувь/
		100%	90%	70%	50%	30%	10%			
1. Уул уурхайн сайдын дангаар хэрэгжүүлэх										
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	16	7	5	4						89.37
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	2	1		1						75.0
Дүн	18	8	5	4	1					87.78

2. Уул уурхайн сайдын толгойлж хэрэгжүүлэх									
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	19	3	12	4					87.36
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	6	1	1	3	1				75.0
ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН	5	4			1				90,0
Дүн	30	8	13	7	2				85.33
3. Бусад яам, газартай хамтарч хэрэгжүүлэх									
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	30	11	5	9	3	1		1	81.3
1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	6	1	2		1	2			65.0
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	2	2							100,0
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	2				1			1	50.0
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого	4	2	2						95.0
ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН.	1	1							100,0
ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН	4				2			2	50.0
Гадаад харилцаа	2	1		1					85.0
Нийгмийн аюулгүй байдал	4	3			1				87,5
ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН	24	14	7	1	1	1			90,83
Дүн	79	35	16	11	9	4		4	83.73
НИЙТ ДҮН	127	51	34	22	12	4		4	84.71

1.2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 07 сарын 01-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхайн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах 2 дугаар зорилтын 2.2, Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын 4.1, Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх зорилтын 9.2, 9.3, 9.4, 9.5 дахь нийт 6 зорилт, арга хэмжээ нь тус яамны эрхлэх асуудалд хамаарч байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн 6 зорилт, арга хэмжээнээс 1 арга хэмжээ бүрэн биелсэн, бусад 5 арга хэмжээ хэрэгжих шатандаа 50-аас 90 хувийн биелэлттэй буюу нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 2015 оны жилийн эцсийн байдлаар 81,7%-тай.

Үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2016 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 1/218 тоотор СЯ-нд хүргүүлж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж ажилласан.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Бодлогын зорилт	Заалтын тоо	/2015 оны жилийн эцсийн байдлаар/						
			Хэрэгжилтийн явц /хувь/						
			100%	90%	70%	50%	30%	10%	0%

1	Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	1	1	-	-	-	-	-	-	100.0
2	Зорилт 4. Гадаад худалдааны бодлогоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.	1	-	1	-	-	-	-	-	70.0
3	Зорилт 9. Уул уурхайн салбарыг дэмжих чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.	4	-	2	1	1	-	-	-	65.0
Дүн		6	1	3	1	1	-	-	-	81.7

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан Уул уурхайн яамны хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг үзүүлбэл:
70 хувийн хэрэгжилттэй

9.4. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх.
50 хувийн хэрэгжилттэй

9.5. Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх.

1.3. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ.

Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын тухай Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн биелэлтэд 2015 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Уул уурхайн яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх, Олборлох үйлдвэрийн техник, технологийн, Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, Нийтлэг асуудал гэсэн 5 ангиллаар хяналтад авч нийт 268 шийдвэрийн 399 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 27 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 92.5, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх 49 шийдвэрийн 67 заалтын хэрэгжилт 94.6, олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудлын 19 шийдвэрийн 19 заалтын хэрэгжилт 99.6, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын 87 шийдвэрийн 125 заалтын хэрэгжилт 96.6, нийтлэг асуудлын 86 шийдвэрийн 154 заалтын хэрэгжилт 91.6 хувийн тус тус биелэлттэй.

Эдгээрийг тогтоол шийдвэрийн агуулгаар нь ангилж авч үзвэл:

№	Ангилал	Шийдвэр	Заалт	Үнэлгээ /%/
1	Геологи, эрдэс баялгийн бодлогын	27	34	92,5
2	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын	49	67	94,6
3	Олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудлын	19	19	99,6
4	Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогын	87	125	96,6
5	Нийтлэг асуудлын	86	154	91,6

Уул уурхайн яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний УИХ, Засгийн газрын шийдвэрийн нийт 268 шийдвэрийн 399 заалтыг хяналтад авснаас УИХ-ын 6 тогтоолын 29 заалт, УИХ-ын байнгын хорооны 6 тогтоолын 10 заалт, Засгийн газрын 96 тогтоолын 153 заалт, Ерөнхий сайдын 19 захирамжийн 25 заалт, Засгийн газрын 141 хуралдааны тэмдэглэлийн 182 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ерөнхий дүнгээрээ 95,5 хувийн биелэлттэй.

Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

	Хяналтанд авсан	Хэрэгжилт /хувь/	Ху га	Үн өл с

Тогтоол шийдвэр		Шийдвэр-ийн тоо	Заалтын тоо	100	90	70	50	30	10		
УИХ-ын шийдвэр	УИХ-ын тогтоол	6	29	20	2	1	1	2		3	90,7
	УИХ-ын байнгын хорооны тогтоол	6	10	7	1	1	1				91,0
ЗГ-ын шийдвэр	ЗГ-ын тогтоол	96	153	116	12	7	7	1		10	94,7
	ЕС-ын захирамж	19	25	24		2					97,6
	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	141	182	155	7	3	4	1	1	11	96,6
Ерөнхий дүн		268	399	322	22	14	13	4	1	24	95,5

Тайланг 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/89 тоотор ЗГХЭГ-т хүргүүлж, сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж үнэлгээний дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

1.4. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнахдаа Засгийн газрын 2010 оны 95 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд эхний шатны үнэлгээ хийх төлөвлөгөө”-ний 2015 онд хүрэх үр дүн буюу эхний үе шатанд хамрагдах Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Тус яамны эрхлэх асуудалд хамаарах геологи, уул уурхай, түлшний салбарын үйл ажиллагаатай холбоотой 29 зорилтын 46 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын 2015 он хүртэлх эхний үе шатанд тус яамны хэрэгжүүлсэн 46 арга хэмжээ хэрэгжих шатандаа, биелэлт ерөнхий дүнгээр 79,0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/219 тоотор СЯ-нд хүргүүлж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж ажилласан.

1.5. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын 2008 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” Швейцарийн хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байна. Уг дэд хөтөлбөр нь 2 үе шаттай хэрэгжсэн бөгөөд 1-р үе шат 2008-2011 онд, 2-р үе шат 2012-2015 он хүртэл хэрэгжсэн байна.

Уг дэд хөтөлбөр нь Хувиараа ашигт малтмал олборлогчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, улмаар уул уурхайн дэд салбар-“Бичил уурхай”-н загварыг бий болгох, Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагааг бичил уурхай болгож, зохих техник, технологи хэрэглэхэд дэмжлэг үзүүлж, аюулгүй ажиллагааны шаардлага хангуулах, Нөхөрлөлийн зохион байгуулалттайгаар ашигт малтмал олборлогчид болон тэдний гэр бүлийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, ажлын байр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах гэсэн үндсэн 3 гол зорилтын хүрээнд “Тогтвортой бичил уурхай төсөл”, Ашигт малтмалын газар, бичил уурхай бүхий орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж 2014 оны жилийн эцсийн байдлаар уг дэд хөтөлбөрийн 1-р зорилтын хэрэгжилт 68%, 2-р зорилт 83.3%, 3-р зорилт 82.5%-ийн тус тус биелэлттэй, дундаж үнэлгээ 78,0%-ийн хэрэгжилттэй дүгнэгдэж дууссан байна.

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг Монголбанк, Уул уурхайн яам хоорондын 2012 оын 10 дугаар сарын 26-ны өдрийн А-171/46 дугаар хамтарсан тушаалаар батлан амжилттай хэрэгжүүлж дууссан байна. Дэд хөтөлбөр хэрэгжсэнээр шатахуун импортлогч компаниудад

хөнгөлөлттэй зээл олгон, санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан ханшийн эрсдлийг бууруулах замаар гадаад валютын ханшийн өсөлт, шатахууны хилийн үнийн өсөлтөөс үл хамааран шатахууны жижиглэн худалдааны үнийг тогтворжуулж зохих үр дүнд хүрсэн гэж үзэж хөтөлбөрийг хаасан байна.

1.6. УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Зээл, буцалтгүй тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийг 2015 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл:

БНСУ-ын КИГАМ-аас санхүүжигдэж байгаа “Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх” төсөл 70,0 хувьтай, Хасагт төсөл 100,0 хувьтай, “Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогени” ОУ-ын төсөл 70,0 хувьтай, Швейцарийн Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хийгдэж байгаа “Тогтвортой бичил уурхай” төсөл 80,0 хувьтай, Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төсөл 55,0 хувьтай, Монгол-Алтай-50 төсөл 70,0 хувьтай, ХБНГУ-ын Холбооны Геошинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэн, АМГ-тай хамтарсан “Монгол Улсын Ашигт малтмалын газрын эрдэс баялагийн салбарын эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх” техник хамтын ажиллагааны төсөл 70,0 хувьтай, Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1:50000, 1:200000-ны масштабын геологийн судалгааны ажлууд 79,3 хувьтай байна.

Дээрх төслүүдийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ нь ерөнхий дүнгээрээ **74,3** хувьтай байна.

Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явц

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

Төслүүдийн нэр	Эрх зүйн үндэслэл /Гэрээ, санамж бичиг, шийдвэр /тогтоол, тушаал/, огноо/	Хэрэг жүүлэх хугацаа /оноор/	Санхүү жилтийн эх үүсвэр	Хийсэн ажлын явц	Тайлбар
Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх”	Монгол Улсын Ашигт малтмалын газар, БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн /КИГАМ/ хооронд байгуулсан санамж бичиг 2010.03.31	2010.03.31-2015.12.31	Кигам (БНСУ-ын төсөв)	70,0	Тайлангийн бичвэрт ямарч шинжилгээний хариу тусгагдаагүй, одоог хүртэл дээж нь ГСТ-ын агуулахад хадгалагдаж байгаа болон хээрийн ажилд, эрлийн ажил, эрлийн талбай, тэдгээрт дагалдах уул, геофизикийн ажил хийгдээгүй талаар дурьджээ.
Хасагт-ын талбайд геологийн судалгааны болон эрлийн цогц ажил явуулах	МУ-ын ҮХЯ болон БНПУ-ын Байгаль орчны сайд нарын хооронд байгуулсан гүйцэтгэлийн гэрээ 2008-02-14	2008.02.14-2018.12.31	МУ-аас Польш улсад төлөх өрийг зохицуулах хэлэлцэ эрийн дагуу	100,0	Эцсийн үр дүнгийн тайланг Польшийн тал боловсруулж, 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 08/63 албан тоотой битүүмжлэгдэж ирсэн 5 боть /англи хэл дээр бичигдсэн/ хавтаст материалыг АМГ-ын ГА 2016.01.15-ны өдөр хүлээн авсан байна.
Хойд-Төв-Зүүн Азийн 3-н хэмжээст геологийн структурууд ба металлогени ОУ-ын төсөл	Монгол, ОХУ, БНХАУ, Казакстан улсуудын хооронд байгуулсан гэрээгээр	2010-2020	Улсын төсөв	70,0	-
Тогтвортой бичил уурхай	МУ-ын Уул уурхайн яам,	I үе шат 2005-	Буцалтгүй	80,0	Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор

төсөл	Швейцарийн хөгжлийн агентлагийн (ШХА) хооронд 2011 оны 3 сарын 28-ны өдөр байгуулсан Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжүүлэх тухай гэрээ	2006 II үе шат 2007-2010 III үе шат 2011-2014 IV үе шат 2015-2018	туслам ж	<p>батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг боловсронгуй болгох, сайжруулах үүднээс Бичил уурхайн Үндэсний чуулганы үеэр хэлэлцүүлж нэмэлт саналыг тусгасан. Журмын төсөл Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон байна.</p> <p>2015 онд төслийн 4 дэх үе шат эхэлсэнтэй холбогдуулан Уул уурхайн сайдын 2015 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 26 дугаар тушаалаар төслийн Удирдах хороо байгуулагдсан. Удирдах хорооны бүрэлдэхүүнд бичил уурхайтай холбоотой гол яам, агентлагуудын, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Монгол банк, Хүний эрхийн үндэсний комисс, Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, ШХА болон ТБУТ-ийн төлөөлөл томилогдсон. 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн Удирдах хорооны анхдугаар хуралдаанаар төслийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталжээ.</p> <p>Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг сайжруулах, бичил уурхайчдыг зохион байгуулалтад оруулах, үйл ажиллагааг нь албажуулах ажлын хүрээнд АМГ-ын үйл ажиллагааг дэмжих, бичил уурхай бүхий аймаг сумдын нутгийн удирдлагын байгууллага болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын ажилтнуудын чадавхийг сайжруулах, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас бичил уурхайн чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчдын бизнес эрхлэх санал санаачлагыг дэмжих, бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаар холбогдох</p>
-------	--	--	-------------	---

					<p>талуудтай хамтарч ажиллах, бичил уурхайн олон улсын мэдлэгийн төв байгуулах ажлыг эхлүүлэх ажлууд хийгдэж байна.</p> <p>Төрөөс эрдэс баялгийн салбарт 2014-2025 онд баримтлах бодлогод бичил уурхай асуудлыг тусгаж төрөөс бичил уурхайн талаарх бодлого тодорхой болсноор үндэсний болон орон нутгийн түвшний төрийн бүх шатны байгууллагууд бичил уурхайн асуудалд анхаарал хандуулж тэдгээрийг зохион байгуулалтад оруулах, бичил уурхайчдын аюулгүй ажиллагаа, нийгмийн хамгаалал, даатгал, эрүүл мэнд, хүний эрх, байгаль орчны асуудалд оролцдог болсон сайн талтай. УУЯ, АМГ-аас гадна ХАХНХЯ, ХЯ, ЭМСЯ, НЭМҮТ, НДЕГ, ОБЕГ, ХЭҮК зэрэг төрийн байгууллагууд болон Төрийн бус байгууллагууд Бичил уурхайд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.</p>
Нүүрснээс синтетик хий үйлдвэрлэх, экспортлох	Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 74 дүгээр тогтоол		Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн зээл	55,0	Нийт 991,856.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 546,971.2 мянган төгрөг буюу 55,2 хувийн санхүүжилт хийгдсэн байна. Санхүүжилт дутуу хийгдсэнээр төлөвлөсөн ажил бүрэн хийгдэх боломжгүй болж, үнэлгээ багаар үнэлэгдсэн байна.
Монгол-Алтай-50, 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	БНЧУ-ын Геологийн албатай хамтран гүйцэтгэх 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр гэрээнд гарын үсэг зурсан.	2013.04.09-2016.06.30	БНЧУ-ын төсөв	70,0	Хээрийн ажлын биелэлт 100% хийгдсэн ба суурин судалгааны боловсруулалтын ажил хийгдээгүй байна.
“Монгол Улсын Ашигт малтмалын газрын эрдэс баялагийн салбарын эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх” техник хамтын	ХБНГУ-ын Холбооны Геошинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэн, АМГ-тай хамтарсан 2014 оны 9 сарын 17-ны	2014.04.01-2016.04.01	ХБНГУ-ын төсөв	70,0	Холбогдох сургалт, хурал, танилцах аялалд АМГ-ын удирдлага, ажилтан нийт 37 хүнийг хамруулсан байна. Цахим тайлангийн ажлын даалгаврыг БГР-ийн зөвлөх Томас Спэйш, ХШҮСМХ-ийн ахлах мэргэжилтэн А.Отгонбаатар нар хамтран боловсруулж дуусган

ажиллагааны төсөл	өдөр гэрээнд гарын үсэг зурсан.				хүлээлгэн өгсөн. Програм боловсруулах сонгон шалгаруулалт явагдаж гүйцэтгэгч компани сонгогдон ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 25 хувь. Нэгдсэн мэдээллийн сангийн ажлын даалгаврыг БГР-ийн зөвлөх Томас Спэйш, ХШҮСМХ-ийн ахлах мэргэжилтэн А.Отгонбаатар нар хамтран боловсруулж дуусган хүлээлгэн өгсөн. СМС-ийг сайжруулах, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд нийцүүлэн өргөтгөх ажлын даалгаврыг БГР-ийн зөвлөх Томас Спэйш, ХШҮСМХ-ийн ахлах мэргэжилтэн А.Отгонбаатар нар хамтран боловсруулж дуусган хүлээлгэн өгсөн. GAF Ag компанитай байгуулсан BGR-ийн гэрээний дагуу АМГ-аас ажлын хэсэг байгуулан зохих ажлуудыг хийж байна. Ажлын явц 30 хувь. 2015 оны 9 сард “Монгол улсын төмрийн хүдрийн ордууд, өнөөгийн байдал, хэтийн төлөв, зах зээл”-ийн судалгааг хийж эхэлжээ.
Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажил	Уул уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 48 дугаар тушаал	2012-2018	Улсын төсөв	79,3	Төслийн зорилтуудын хэрэгжилтийг үндэслэн төслүүдийг үнэлсэн. 50%-тай үнэлэгдсэн: Баяндалай-50, Суман хад-50, Хайлааст-Уул-50, Алтай-2, Цул Сульфид БМ-2014
Дундаж үнэлгээ /хувь/				74,3	

II. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ.

2.1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ.

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 364 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч Ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон түүний биелэлтийг дүгнэх журам”-ын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч-Уул уурхайн сайд Ерөнхий менежер-УУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргатай 2015 онд байгуулсан Үр дүнгийн гэрээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан 2015 оны Үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт **95,8** оноогоор дүгнэгдэж, Төсвийн ерөнхийлөн захирагч нь Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг “А” буюу “маш сайн” гэж үнэлсэн.

Уул уурхайн яамны Төсвийн шууд захирагчийн
Үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээ

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

Үр дүнгийн гэрээний үзүүлэлт	Төлөвлөсөн ажлын тоо	Өгвөл зохих оноо	Гэрээний биелэлтийг хянаж өгсөн оноо
Нийт бүтээгдэхүүн /тусгай	302	0-30	27,8

захиалгат бүтээгдэхүүнээс бусад/-ийн нийлүүлэлт			
Тусгай захиалгат бүтээгдэхүүний нийлүүлэлт	151	0-40	38,0
Манлайллыг хэрэгжүүлэх зорилтын биелэлт	2	0-30	30,0
Нийт оноо	455	0-100	95,8

Төсвийн ерөнхийлөн захирагч, Уул уурхайн сайд Р.Жигжид, Ерөнхий менежер, Төрийн нарийн бичгийн дарга Д.Артаг нарын байгуулсан Үр дүнгийн гэрээний хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагчид 2015 онд нийлүүлэх ажил үйлчилгээний жагсаалт”-д нийтдээ 472 ажил үйлчилгээ, төлөвлөгдсөн ба эдгээрээс дараах 16 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийгээгүй болно. Үүнд:

1.2.2.6. *Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах Монгол улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд 2015 онд Берлин хотноо болох Уул уурхайн ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж, хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэнэ.*

1.2.5.1. *Энэтхэг улсад зохион байгуулагдах Clean Coal 2015 чуулга уулзалтад оролцох яамны төлөөллийн бэлтгэл ажлыг хангана.*

1.2.5.3. *Хонгконг улсад зохион байгуулах Invest Mongolia Hong Kong 2015 чуулга уулзалтын яамны төлөөллийн оролцох бэлтгэл ажлыг хангана.*

1.2.5.6. *Лондон хотноо зохион байгуулагдах “Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-д яамны төлөөллийн оролцох бэлтгэл ажлыг хангана.*

1.2.6.2. *Япон, БНСУ, БНХАУ, ОХУ-д хийн бодлого судлах сургалтад яамны төлөөллийн оролцох бэлтгэл ажлыг хангана.*

3.1.13.2. *“Жонш” хөтөлбөр боловсруулах/ 2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах*

3.1.13.4. *“Цайр ба холимог металл” хөтөлбөр боловсруулах/ 4.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах*

3.4.4.1. *БНХАУ-тай Монгол Хятадын Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Салбарын Хамтын Ажиллагааны дэд зөвлөлийн тавдугаар хуралдааныг 2015 онд Бээжин хотноо зохион байгуулж, эрдэс баялгийн салбар дах хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэх*

4.1.11.1. *Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх байгууллагыг сонгон шалгаруулна.*

4.3.17.1. *Засгийн газрын хуралдаанаар Уул уурхайн сайдын тухайн жилд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлтэнд салбар, нээж тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулна.*

4.3.17.2. *Нээгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна.*

3.1.14 *Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөх журам, гэрээний загварыг батлуулна. 4. Орд ашиглах гэрээ байгуулах журмыг шинэчлэн боловсруулах*

5. *Тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээний загварыг батлах тухай ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулах.*

6. *Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагийг тогтоох тухай ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулах*

3.1.7.2. *Цацраг идэвхт ашигт малтмалын баяжуулах үйлдвэр байгуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг холбогдох байгууллагуудын хамтаар боловсруулах. 3.Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах үйлдвэр байгуулах асуудлаар ҮАБЗ-д зөвлөмж гаргуулахаар хүргүүлэх.*

10%-ийн биелэлттэй 1 ажил үйлчилгээ:

3.4.1. *Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх санхүүжилтийн асуудлын эрх зүйн орчныг бий болгож, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно. /ЗГҮАХ-54.2/ 1.Төсвийн төсөлд санал хүргүүлж, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн сан бий болгох талаар БОНХАЖЯ-тай хамтран ажиллах.*

Ерөнхий менежерээс 2015 онд Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлбэл зохих нийтдээ 472 ажил үйлчилгээ төлөвлөснөөс биелэлт гаргасан 455 ажил үйлчилгээний биелэлт 93,5%-тай, 4,6 оноогоор дүгнэлээ. Үүнд:

Нийтдээ хэрэгжүүлсэн 455 ажлын 344 /75,6%/ нь тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн буюу 100 хувийн гүйцэтгэлтэй;

57 ажил /12,5%/ нь зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90 хувийн гүйцэтгэлтэй;

21 ажил /4,6%/ нь гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн гүйцэтгэлтэй;

26 ажил /5,7%/ нь бэлтгэл болон боловсруулалтын ажил хийгдэж тодорхой хэмжээнд ажил нь эхэлсэн буюу 50 хувийн биелэлттэй;

6 ажил /1,3%/ нь бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатны ажил хийгдэж байгаа буюу 10-30 хувийн тус тус биелэлттэй дүгнэгдлээ.

2.2. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.


Уул уурхайн яам нь 2015 онд 5 стратеги зорилтын хүрээнд нийт 455 арга хэмжээ /ажил үйлчилгээ/ төлөвлөж хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний биелэлтийн тайлан, үр дүнгийн хүрсэн түвшинд үндэслэн хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл 93,5 хувьтай дүгнэгдэв.

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ

2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Стратегийн зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ %
Стратегийн зорилт 1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;	121	95,7
Стратегийн зорилт 2. Геологи, уул уурхайн салбарын стратеги, хөтөлбөр болон шийдвэрийн төслийг боловсруулах, ойрын болон хэтийн төлөв, салбарын бодлогыг тодорхойлох, хууль тогтоомж, бодлого, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хөтөлбөр боловсруулах;	111	93,5
Стратегийн зорилт 3. Хууль тогтоомж, бодлогын дүн шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;	72	94,3
Стратегийн зорилт 4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах;	106	91,9
Стратегийн зорилт 5. Түлшний талаарх хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөрийн төсөл боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;	45	90,6
Дундаж үнэлгээ	455	93.5

▪ ЗГ-ын 2012 оны 126 дугаар тогтоолын дагуу жил бүр улсын болон компанийн нөөцийг тогтмол бүрдүүлэн ажиллаж байна. 2015 онд нөөц бүрдүүлэх талаар Засгийн газрын 412 тоот тогтоолыг батлуулж нөөцийг бүрдүүлж ажилласан.



2012 онтой харьцуулахад компанийн нөөц бүрдүүлэлтийн хэмжээ нийт дүнгээр 20.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

▪ "Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай" хуулийн төслийг боловсруулж УИХ-ын чуулганы 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Хууль батлагдсантай холбогдон дагаж гарах журмуудыг боловсруулахаар ХЗЯ-тай хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаа.

▪ Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг тус тус боловсруулан хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төсөлд ЗГ-ын ХЭГ-ын зөвлөмж болон яамдын саналыг тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгоод байна.

▪ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-ын 2014 оны 7-р сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Үүнтэй холбогдуулан “Төсвийн тухай”, “Хүний хөгжил сангийн тухай” хуулиудад нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан УИХ-ын 2015 оны 5-р сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав. Дээрх өөрчлөлтөөр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос томоохон төсөл хэрэгжүүлэгчдийн орлогыг хассан дүнгийн 30%, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50%-ийг тус тус орон нутагт нь хуваарилдаг болсноор хайгуулын ажилд зарцуулах хөрөнгө оруулалт нэмэгдэж улсын эрдэс баялийн сан нэмэгдэх нөхцөл бүрдсэн.

▪ Монгол орны хэмжээнд өмнө хийгдсэн геологийн судалгааны материалуудыг нэгтгэн зохиох Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нутаг дэвсгэрийн 82% хийж гүйцэтгээд байна. 2013-2016 онд хэрэгжүүлэх Төв Монгол-VI, VII, Дорнод Монгол-VI, VII төслүүдийн 2015 оны төлөвлөгөө, төсвийг УУС-ын 33-р тушаалаар батлуулсан. Төслүүдийн төсвийн тодотголыг эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-өөр хэлэлцүүлсэн.

▪ Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны объектыг тодруулах төслийн 2015 оны төсөв, төлөвлөгөөг УУС-ын 2015 оны 33-р тушаалаар батлуулсан. Төслийн 2014 оны ажилд хяналт хийж, хээрийн судалгааны анхдагч материалыг хүлээн авсан. Төслийн 2015 оны хээрийн судалгааны ажлын хэмжээ, аргачлөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлээд байна.

▪ Баян-Өлгий, Ховд аймгийн нутгийг хамарсан М-45-XXXVI, М-46-XXXI, L-46-I, II, L-46-VII, VIII хавтгайд 1:200000-ны масштабын агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг Ховд-I талбайд шинээр хийх ажлын хэмжээ, үр дүн, судалгааны түвшинг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцээд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын нутгийг хамарсан Алтай-1, Алтай-2 талбайд уг судалгааг хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулж батлуулсан. Төслийн ажлыг 2014 онд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тухайн онд гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг шалгаруулан гэрээ байгуулсан. Төслийн 2015 оны ажлын төсөв, төлөвлөгөөг УУС-ын 2015 оны 33-р тушаалаар батлуулсан. Төслийн 2015 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн аваад байна.

▪ Газрын ховор элементийн металлогени, хэтийн төлвийн судалгааг хийх ажлын хүрээнд 2015 оны ажлын төлөвлөгөө, төсвийг УУС-ын 33-р тушаалаар батлуулсан. Монгол орны бүс нутгийн металлогений 1:1000000-ны масштабын зураг зохиох төслийн зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлэн 2015 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болон анхдагч баримт материалыг хүлээн аваад байна.

▪ Геологийн зураглалын ерөнхий эрлийн ажил /1:50000/-аар нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулах зорилтын хүрээнд 2015 оны хагас жилийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 32 хувь, 2015 онд шинээр 14 төсөл, 3 бүлэгчилсэн төсөл хэрэгжүүлэн ажиллаж жилийн эцсийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 36% хамрагдсан дүнтэй байна.



▪ Монголын Геологийн Албыг байгуулах, чиг үүргийн талаар Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, “Ашигт малтмалын тухай хууль”-д тус тус тусган батлуулсан. Уул уурхайн сайдын 2012 оны 78 дугаар тушаалаар байгуулагдсан Үндэсний геологийн алба байгуулах талаар санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж геологийн албаны бүтэц, зохион байгуулалтын талаар боловсруулсан төсөл, ЗГ-ын тогтоолын төслийг Уул уурхайн

яамны удирдлагын зөвлөл, Уул уурхайн сайдын зөвлөл, Эрдэс баялгийн бодлогын зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж гарсан санал, зөвлөмжийг төсөлд нэмж тусган яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлээ.

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн иргэдийн оролцоог хангах талаар Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж батлууллаа. Мөн уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж хуралдааны тэмдэглэл гаргуулав. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг орон нутгийн саналд тулгуурлан зөвхөн төрөөс тогтоосон газарт олгох, хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож болох талбайг солбицлоор тогтоох талаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг үр дүнгээ Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн найруулсан. Уг хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагтай Засгийн газраас баталсан хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах заалт орж ингэснээр орон нутаг, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд зөрчил гарахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүллээ.

- "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох саналыг шийдвэрлэхэд тухайн баг, сумын иргэдийн оролцоог хангах заалтыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд оруулсан. Ингэснээр аймаг, нийслэлийн Засаг дарга түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох эрх зүйн орчин бүрдэж төвлөрөл саарч орон нутгийн иргэдийн оролцоо хангагдах нөхцөл бүрдсэн. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгож эхэлснээр 864 тусгай зөвшөөрөл шинээр олгоод байна. Аймгуудын Засаг дарга нараас санал авахаар хүлээгдэж байгаа 31, Засаг дарга дэмжээгүйгээс шийдвэрлэгдээгүй 627 өргөдөл байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр 3436 тусгай зөвшөөрөл байгаагаас хайгуулын 1939, ашиглалтын 1497 тусгай зөвшөөрөл байна.

- Аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд олгох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоонд хязгаарлалт тавих тухай заалтыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулсан бөгөөд нэг хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгох талбайн хэмжээ хуучин хуулиар 400 мянган га байсныг 150 мянган га болгож багасгасан. 2015 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын нийт 3436 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаагаас хайгуулын 1939, ашиглалтын 1497 тусгай зөвшөөрөл байна. Эдгээр нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 8.6 хувийг эзэлж байна.

- Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах заалтыг бодлогын баримт бичиг болон хуульд тусгуулсан. Эрдэнэт, Оюутолгой, Тавантолгой, Багануур зэрэг томоохон уурхай, уулын үйлдвэрийг түшиглэсэн дагалдах салбаруудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллаж байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн хүдэр баяжуулах хүчин чадлыг 6 сая тонноор нэмэгдүүлж, жилд 32 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадлыг эзэмшсэнээр үйлдвэрийн хэвийн, найдвартай үйл ажиллагаа хангагдаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэх боломж бүрдэж байна.

- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулиар уурхайн нөхөн сэргээлт, хаалтын журмыг Уул уурхайн сайд, БО-ны асуудал эрхэлсэн сайд хамтран батлах шинэ эрх зүйн орчин бүрдсэн. "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын баримт бичигт заасны дагуу Австрали, Канад зэрэг эрдэс баялаг ихтэй 8 орныг эгнээндээ нэгтгэсэн КРИСКО олон улсын байгууллагад Монгол Улс 9 дэх гишүүнээр элсэн орж олон улсад мөрддөг стандартын дагуу нөөц баялагаа тайлагнаж олон улсын биржид хөрөнгө босгох боломж нөхцлийг бүрдүүллээ.

- Ашигт малтмалын экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулаад байна.

- Цацраг идэвхт ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, шаардлагатай тохиолдолд эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, холбогдох хуулийн хэрэгжилтийн талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхайн сайдын 2013 оны 05 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд өнөөгийн байдлаар Монгол орны хэмжээнд тогтоогдсон ураны ордын нөөцийн талаар судалгаа, мэдээллийг нэгтгэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж нөөцийг хүлээн авлаа. Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Арева Монгол компанитай орд ашиглах гэрээ байгуулахаар ажиллаж байна.

- 2015 онд "Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуулиар тодорхойгүй нөхцөл байдалд ороод байсан алт

олборлогчдын үйл ажиллагаагаа сэргэсэн. “Алт олборлолтыг эрчимжүүлж, эдийн засгийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 94 дүгээр тогтоолыг батлуулж хэрэгжүүлсэн. Алт худалдан авах урьдчилсан санхүүжилтийн тогтолцооны тухай 311 дүгээр тогтоол батлагдаж 256 тэрбум хүртэлх төгрөгийн санхүүжилтийг алт олборлогч аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгөд хөнгөлөлттэйгөөр олгох болсон зэрэг бодлогын алхамуудыг хийлээ. Монголбанкинд алт тушаалт 2015 онд 15 тн болж нэмэгдсэн ба 2016 онд 18 тн болж өсөх төсөөлөлтэй байна.



▪ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллаж хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг бодлогоор дэмжиж, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичиг, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд зохих өөрчлөлтүүдийг оруулсан. Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, түүний хавсралтуудын төслийг боловсруулаад байна.



▪ "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга" зарчим болон шалгуурыг тус санаачилгын Ажлын албатай хамтран хэрэгжүүлж Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар ажлын төлөвлөгөө боловсруулж, бага хурлыг зохион байгуулсан. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтын хүрээнд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай” хуулийн төслийг боловсруулж олон нийтийн хэлэлцүүлэг

зохион байгуулж хуулийг төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлэ УИХ-д өргөн бариад байна.

▪ Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг Засгийн газар батлахаар заасны дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварын төслийг боловсруулж, 2015.03.16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын 104 дүгээр тогтоолоор батлуулав.

2.3. ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2014 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн 2014 оны хэрэгжилтэд хийсэн хяналт- шинжилгээ үнэлгээний дүн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн үнэлгээний дүн, Үндэсний хөтөлбөрүүдийн 2014 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнд үндэслэн гүйцэтгэл нь удааширч буй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах зорилгоор яамны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг сайдын 2015 оны 123 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. Төлөвлөгөөнд Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2, эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 4, дээд байгууллагын 6 шийдвэр, нийт 12 ажлыг оруулж хэрэгжилтийг дүгнэлээ. Бодлогын газруудаас ирүүлсэн биелэлтээс харахад Үндсэн чиглэлд тусгагдсан 4 арга хэмжээний биелэлт 90-100 хувийн хэрэгжилттэй, ЗГҮАХ-т тусгагдсан 2 арга хэмжээний биелэлт 50 хувийн биеэлэлттэй, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт хангалтгүй байв. Тухайлбал Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл хангах үүрэг бүхий төслийн нэгжийг УУЯ-ны дэргэд байгуулах тухай Засгийн газрын 2014 оны 139 дүгээр тогтоол, Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах яамны салбар зөвлөл байгуулах тухай Ерөнхий сайдын 2014 оны 61 дүгээр захирамж, "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай" НҮБ-ын конвенцийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2013 оны 281 дүгээр тогтоол зэрэг нийтлэг асуудлаар гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.4. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ.

Аймгийн Засаг дарга нартай 2015 онд хамтран ажиллах гэрээг 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан. Нийт 21 аймгийн Засаг дарга гэрээний биелэлт ирүүлсэн бөгөөд гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **79.9** хувьтай. /хүснэгт-1/

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран
ажиллах гэрээний биелэлтэнд өгсөн үнэлгээ
/2015 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

дд	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувь						Дүгнээгүй	Биелэлт, хувь	
					100	90	70	50	30	10			0
1	Архангай	Д.Бат-Эрдэнэ	1	11	3	2	1	3	-	-	-	2	77.8
2	Баян-Өлгий	Х.Дармен	2	11	5	4	-	1	-	-	-	1	91.0
3	Баянхонгор	Д.Жаргалсайхан	3	11	6	4	1	-	-	-	-	-	93.6
4	Булган	Д.Эрдэнэбат	4	11	4	1	2	2	-	-	-	2	81.1
5	Говь-Алтай	О.Амгаланбаатар	5	11	2	3	1	-	-	-	4	1	54.0
6	Говьсүмбэр	Л.Одсэр	6	11	7	2	-	-	-	-	-	2	97.8
7	Дархан уул	С.Насанбат	7	11	2	1	5	2	1	-	-	-	70.0
8	Дорноговь	П.Ганхуяг	8	11	3	4	1	1	-	-	-	2	77.7
9	Дорнод	С.Ганбат	9	11	4	4	2	-	-	-	-	1	90.0

10	Дундговь	С.Од-Эрдэнэ	10	11	10	1	-	-	-	-	-	-	99.0
11	Завхан	Ж.Жамъянтив	11	11	-	2	5	2	-	-	-	2	70.0
12	Орхон	Д.Энхбат	12	11	-	3	3	2	-	-	-	3	72.5
13	Өвөрхангай	Д.Тогтохсүрэн	13	11	5	3	-	1	-	-	1	1	82.0
14	Өмнөговь	Б.Бадраа	14	11	7	3	-	-	-	-	1	-	88.2
15	Сүхбаатар	Ж.Батсуурь	15	11	5	2	2	-	-	-	-	2	91.1
16	Сэлэнгэ	С.Бүрэнбат	16	11	5	2	2	1	-	-	-	1	87.0
17	Төв	Д.Баярбат	17	11	2	2	5	-	-	-	-	2	81.1
18	Увс	Д.Цэндсүрэн	18	11	1	2	4	2	-	-	1	1	66.0
19	Ховд	Д.Цэвээнравдан	19	11	-	4	4	1	-	-	-	2	76.6
20	Хөвсгөл	А.Эрдэнэбаатар	20	11	-	1	2	3	-	-	1	4	64.2
21	Хэнтий	Ж.Оюунбаатар	21	11	2	4	1	1	-	-	2	1	68.0
		НИЙТ											79.9

2.5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журмын дагуу Уул уурхайн яамны 2015 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 100 оноо бүхий шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 90,0 оноо, худалдан авах ажиллагааны хэрэгжилт 89,37 оноогоор тус тус үнэлэгдэв.

2015 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ажил он дамжин хийгдсэн ба Уул уурхайн сайдын төсвийн багцаас 12, Зээл тусламжийн хөрөнгөөр 1, Төлөөлөгчдийг дэмжих сангийн хөрөнгөөр 5, нийт 18 төсөл арга хэмжээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төлөвлөсөн.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

/2014 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	Батлагдсан төсөвт өртөг /сая төгрөг/	Гэрээний дүн /сая төгрөг/	Тайлбар	Үнэлгээ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:					
1	Замын-Үүдийн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт	3,593.0	3,593.0	Эм-Пи-Ай Консалтинг ХХК 014 оны 10 сарын 15-ны өдрийн 15 тоот гэрээ байгуулан ажилласан. 2015 онд бүрэн ашиглалтанд өгсөн. Улсын комисс ажилласан. 2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн. 2015 онд үлдэгдэл 2593.0 сая төгрөгийг хөгжлийн банкны санхүүжилтээр шийдвэрлэхээр тусгагдсан. 2015 онд 1,6 тэрбум төгрөгийг шийдвэрлэж үлдэгдэл 966,1 сая төгрөгийг санхүүжилтийг Сангийн яамнаас болон Хөгжлийн банк	90

				2016 онд шийдвэрлэхээр тохиролцооны дагуу санхүүжилт олгогдоогүй. 2006 оны 1 сард 280,2 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	
	Нийт дүн	3,593.0	3,593.0		90.0
УРСГАЛ ЗАРДАЛ:					
1	Нөөц хөрөнгийн хадгалалт хамгаалалт /Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж/	1,019.2	780.1	Нээлттэй тендер шалгаруулалтыг 2 үе шаттайгаар/4 багцалж/ зарлан 4 багцад шалгарсан НИК ХХК-тай гэрээг байгуулсан боловч тус компанийн шатахууны нөөц хадгалах агуулахад техникийн засвар үйлчилгээ хийх шаардлага гарсны улмаас гэрээг цуцласан. 2015 оны 9 сарын 21-ний өдөр нээлттэй тендерийг 4 багцтайгаар дахин зарласан бөгөөд 10 сарын 21-ний өдөр тендерийг дүгнэж гэрээ байгуулах зөвлөмжийг гаргасан. Сангийн яамны 2015 оны 4-3/6746 тоот албан бичгийн дагуу төсвийн хэмнэлтийн горимд шилжин, гэрээ байгуулах боломжгүй болсныг шалгарсан компаниудад мэдэгдсэн.	/-/
2	Бичиг хэрэг	18.1	18.1	Үнэлгээний хорооноос 10 компанид урилгыг хүргүүлсэн бөгөөд 7 компанийн үнийн саналыг авч харьцуулалтын аргаар үнэлгээг хийн, 4 компанитай гэрээг байгуулан 14.96 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.	100
3	Бичгийн цаас	21.0	7.0	Сар бүр захиалгын дагуу "Финпак" ХХК болон "Таванбогд" ХХК-аас бичгийн цаас болон плоторын цаасны худалдан авалтыг хийж нийт 9.0 сая төгрөг зарцуулсан байна.	100
4	Плоторын цаас		2.0		100
5	Принтерийн хор /өнгөт, хар/		11.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1, 33.2.2 дахь заалтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, байгууллагын хэлтсүүдийн захиалгын дагуу нийт 11.6 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.	100
6	Техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	18.4	4.0	Захиалгын дагуу эвдэрсэн канон, сервер сүлжээ зэрэг тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд тухай бүр шаардлагатай сэлбэг хэрэгслийг худалдан авч нийт 2.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	70
7	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ		10.0	Техникийн комиссын актын дагуу байгууллагын автомашинуудад сэлбэг хэрэгсэл худалдан авч, шаардлагатай засварыг хийлгэн нийт 10.0 сая төгрөг зарцуулсан.	100
8	Байрны урсгал засвар		4.4	УУШТЛ-ын байрны хаалганы цоож, бариул засах, бусад засварын ажил үйлчилгээнд 4.4 сая төгрөг зарцуулсан.	100

9	Харуул хамгаалалтын хөлс	22.0	18.3	Гэрээг дүгнэж, харуул хамгаалалтын хөлсөнд нийт 13.0 сая төгрөгийг олгоод байна.	90
10	Уул уурхайн компьютержсэн кадастрын системийн шинэчлэл	332.4	176.3	Нэр бүхий 8 компанитай 11 гэрээ байгуулан 122,9 сая төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авалт хийсэн байна.	90
11	Цогтцэцийн талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх	49.9	49.9	Гэрээний дагуу ажлын тайланг хүлээн авч гүйцэтгэлийг хянан 49.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100
12	Бичиг хэрэг	8.0	8.0	Бичгийн цаас, архивын материалын хавтасны кардон цаас худалдан авахад 142,0 мянган төгрөг зарцуулаад байна.	30
13	Тавилга эд хогшил	2.6	2.6	Компьютер, ширээ сандал авахад 2247,5 мянган төгрөг зарцуулаад байна.	100
14	Тавилга эд хогшил	12.0	12.0	Худалдан авалтанд 12.0 сая төгрөг зарцуулав.	100
15	Газрын тосны ордуудын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, орд ашиглалтын программ хангамж нийлүүлэх	395.0	412.0	206,928.00 ам.долларын үнийн санал ирүүлсэн компанитай гэрээг байгуулж, гэрээний нөхцлийн дагуу санхүүжилтийг олгоод байна.	50
16	Ховд аймгийн төлөөлөгчийн газрын барилгын засварын ажил	30.0	32.2	Байгууллагын даргын 2015 оны 109 дүгээр тушаалаар засварын ажилд хяналт тавих ажлын хэсэг ажиллуулан 8 сарын 25-нд хүлээн авч санхүүжилтийг олгов.	100
17	Монгол улсын "Хүндийн хүчний орон"-ы судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн сан байгуулж, 1:200 000 масштабын зураг зохиох	42.0	40.9	4 компанид урилга хүргүүлснээс "Геосан", "Татах хүч" ХХК-ууд үнийн санал ирүүлж, хамгийн бага үнийн саналаар "Татах хүч" ХХК-тай гэрээг байгуулан санхүүжилтийг олгоод байна.	100
18	Газрын тосны салбарын бүртгэл тооцооны журмыг хэрэгжүүлэх програм хангамж	50.0	50.0	Бүртгэл тооцооны журам батлагдахтай холбогдуудан худалдан авах ажиллагааг 2016 онд шилжүүлээд байна.	/-/
Нийт дүн		2020.7	1521.2		89.37

III. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Уул уурхайн яамны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2009 оны "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" 143 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. 2015 оны жилийн эцсийн байдлаар Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт 97,0%, Хүний нөөцийн бодлогын ил тод байдлын шалгуур үзүүлэлт 92,8% хувийн, Төсөв, санхүүгийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт 94,2 хувийн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт 94,0 хувийн тус тус биелэлттэй, ерөнхий дундаж **95,8** хувь буюу, 4,7 оноогоор дүгнэгдсэн.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Байгууллагын ил тод байдлыг илтгэх

шалгуур үзүүлэлтэд өгсөн үнэлгээ

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Үнэлгээ
Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	10	97,0
Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	7	92,8
Ерөнхий үнэлгээ	17	95,8

3.2. БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИННИЙ ҮНЭЛГЭЭ.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын "Найм"-ын 61-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газраас гаргаж ирүүлдэг. 2015 оны Уул уурхайн яамны шударга байдлын түвшиний үнэлгээг "Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын дагуу Авлигатай тэмцэх газартай гэрээгээр "Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо", "Хөгжлийн санаачлага бодлого судалгааны төв" ТББ-уудын төлөөлөл бүхий шинжээчдийн баг гүйцэтгэжээ. Байгууллагын шударга байдлын түвшиний үнэлгээг төрийн байгууллагын цахим хуудас дахь мэдээлэл, тухайн байгууллагаас ирүүлсэн тайлан болон бусад нотлох баримтад тулгуурладаг байна.

Авилгатай тэмцэх газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/97 тоотой Уул уурхайн яамны шударга байдлын түвшиний үнэлгээний дүнг ирүүлсэн байна.

Үнэлгээнд УИХ-аас байгуулагддаг 7 байгууллага, 15 яам, ЗГ-ын тохируулагч, хэрэгжүүлэгч 28 агентлаг, 22 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээд, нийт 122 байгууллага хамрагдаж, авилгын эсрэг хууль тогтоомжоор төрийн байгууллагын хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70, авилгатай тэмцэх чиглэлээр тухайн байгууллагын удирдлагын санал, санаачлагыг 0-30 оноогоор үнэлж, нийт 100 оноогоор дүгнэсэн ба 2015 оны үнэлгээгээр Уул уурхайн яам 63.2 оноотой үнэлэгдэж 15 яамдаас 9 дүгээрт эрэмбэлэгдэж 2014 оныхоос 2.6 оноогоор ахисан гэжээ. Үнэлгээний оноо өсөхөд байгууллага түүний удирдлагын санаачлага, эрх бүий албан тушаалтан /ЭБАТ/-ны зүгээс гаргаж буй хүчин чармайлтын үр дүнтэй холбон тайлбарласан байна. Мөн үүний зэрэгцээ зарим үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллах талаар зөвлөмж ирүүлсэн байна. Тухайлбал, өмнөх оны санхүүгийн тайлан, тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй, худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, аудит хийсэн тайлан дүгнэлт ил тод нээлттэй бус, тендерийн үнэлгээний хороонд салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулсан талаарх мэдээлэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл ирүүлээгүй, захидал харилцаа хариуцсан ажилтны нэр, харилцах утасны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулаагүй зэрэг дутагдлыг дурдсан байна.

АТГ-аас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг хяналтанд авч, "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. АТГ-аас ирүүлсэн тоотыг хавсаргав.

IV. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВАРЫН ҮНЭЛГЭЭ**4.1. ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.**

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам", "Үзүүлэлт батлах тухай" 2014 оны 68 дугаар тогтоолын 1-р хавсралтын дагуу 2015 оны жилийн эцсийн байдлаар яамны Засаглалын 13 үзүүлэлтийн үнэлгээ 74.5% буюу 3,7 оноогоор дүгнэсэн.

Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Худалдан авах ажиллагааны ил тод байдал, төсвийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд үнэлгээ хийгээгүй болно.

Салбараас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлт 132,1 тэрбум төгрөгөөр тасарсан нь экспортын гол нэрийн эрдэс түүхий эдийн гадаад зах зээл дээрх үнийн уналттай холбоотой байна гэж үзлээ. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 24,2%-аар тасарсан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн урсгал өр буурсан хэдий ч авлага өссөн зэрэг үзүүлэлтүүд үнэлгээнд сөргөөр нөлөөлжээ.

Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үзүүлэлт /АТГ-ын үнэлгээ/ 63,2 хувьтай байгаа нь яамны зүгээс энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ төдийлөн сайжрахгүй байгааг илтгэж байна.

Харин яамнаас боловсруулж буй эрхзүйн акт, шийдвэрт олон нийтийн оролцоог хангах, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын саналыг тусгах тал дээр ахиц гарсан ба иргэд байгууллага, орон нутгаас ирүүлсэн өргөдөл, албан бичгийн шийдвэрлэлт, хувийн хэвшил,

мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, “Хүйсийн тэгш байдлыг хангах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлтийн үнэлгээ өссөн байна.

Засаглалын үзүүлэлтийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

4.2. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, “Үзүүлэлт батлах тухай” 2014 оны 68 дугаар тогтоолын 2-р хавсралтын дагуу 2015 оны жилийн эцсийн байдлаар яамны Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 6 үзүүлэлтийн үнэлгээ 96,8% /2014 оны жилийн мөн үеэс 12,6%-ийн өсөлттэй/ буюу 4,8 оноогоор дүгнэсэн.

Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт өссөн дүнтэй гарсан нь нутаг дэвсгэрийн геологийн 1:50000 масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил, геологийн 1:200000 масштабын иж үрэн зураг зохиох төслийн хэрэгжилт төлөвлөсөн графикт хугацаандаа хэрэгжсэн, газрын тосны олборлолт 15,4% экспорт 7,1%, нүүрсний олборлолт 14,2% экспорт 5,8%, зэсийн баяжмал боловсруулалт 6,8, экспорт 14,1%, төмрийн хүдрийн олборлолт 37,8% экспорт 6,2%, алт олборлолт 46,0% экспорт 13,0%-аар тус тус давж биелсэн нь ерөнхий үнэлгээнд эерэгээр нөлөөлжээ.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

4.3. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зардал яамны 2015 оны төсөвт суугаагүй тул хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тусгайлсан санал асуулга хийгдээгүй болно. Өмнөх жилүүдэд хэрэглэгчийн үнэлгээний үзүүлэлтийг байгууллага, иргэдээс яаманд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд үнэлгээ хийж нэгдсэн тайланд оруулж ирсэн ба 2014 онд хэрэглэгчийн үнэлгээг хийх зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн ажил, хуулийн хэрэгжилт, яамны үйл ажиллагааны нээлттэй байдал, авилга, хүнд суртал зэрэг агуулгын хүрээнд санал асуулга боловсруулж олон нийтийн ord.mn сайтад байршуулан иргэд, олон нийт, салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын саналыг авах ажлыг зохион байгуулж ажилласан. 2015 онд тус газар нь яамны хэрэгжүүлсэн ажлын үр дүнг бүрэн хангуулах үүднээс өөрсдөөс хамаарах арга хэмжээг авч уг ажлын хүрээнд “Эрдэс баялаг-2025” хэлэлцүүлэгт оролцогчдоос санал асуулга авч үр дүнг хэлэлцүүлэгт оролцогчдоод танилцуулсан болно. Уг санал асуулгад нийт 100 гаруй оролцогч хамрагдсанаас 89,0% нь уул уурхайн салбарыг улс орны эдийн засагт тэргүүлэх ач холбогдолтой гэж, 84,0% нь геологи, уул уурхайн салбарын өнөөгийн хөгжил, цаашдын чиг хандлагын талаар засч сайжруулах олон асуудлууд байгаа зэрэг эерэг үзүүлэлтүүд гарсан бол 44,0% нь яамны хэрэгжүүлж байгаа ажлыг хангалтгүй, гарч буй шийдвэрүүд цаг үеэсээ хоцорч байна гэж тус тус үзсэн байна. Мөн салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг 59,0% нь, уг хуулиудын хэрэгжилтийг 57,5% нь боломжийн гэж үзсэн байна.

Санал асуулгад оролцогчдын тоо хязгаарлагдмал байсан, мэргэжлийн байгууллагаар хийгдээгүй, тусгайлсан аргачлал, программ хангамжид тулгуурлаагүй зөвхөн яамны дотоод нэгжийн хүч бололцоонд тулгуурлаж хийсэн байдлыг үндэслэн **85,0** хувь буюу **4,2** оноогоор дүгнэсэн.

V. ДҮГНЭЛТ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Уул уурхайн яамны 2015 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлэлт дүгнэлт өгсөн.

Уул уурхайн яам нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2015 онд төлөвлөсөн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлжээ.

Уул уурхайн яамны 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт 83,8 хувьтай, ерөнхий үнэлгээ 4,1 оноогоор жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнг “сайн” гэж дүгнэв.

VI. ЗӨВЛӨМЖ

Засгийн гарын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргахдаа уг зорилтын хүрээнд хийгдсэн ажил, гарсан

үр нөлөө, хүрсэн үр дүнгийн түвшинг товч тодорхой тайлагнах, тухайн жилд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт гаргах тал дээр асуудал хариуцсан нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд онцгой анхаарах;

Дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтийг тухайн шийдвэр заалтад хамааралтай, тодорхой үр дүнтэй, шийдвэр заалтыг хяналтаас хасуулах саналын хамт гаргаж ирүүлж хэвших;

Хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, төлөвлөлтөд тусгагдсан шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн үр дүнгийн хамт тусгах, бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг харилцан уялдаа холбоотойгоор тайлагнах, мэдээллийг бүрэн оруулах талаар санаачлагатай ажиллах;

Хүрсэн үр дүнг тоон болон дүрс график ашиглан тайлагнах, салбараас улсын эдийн засагт үзүүлсэн бодит нөлөөллийг тооцож байх тал дээр анхаарах шаардлагатай байна.

VI. ХАВСРАЛТ

Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт,

Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт,

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, Худалдан авах үйл ажиллагааны биелэлт,

Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт,

Байгууллагын шударга байдлын түвшиний үнэлгээ /АТГ/,

Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хийсэн үэлгээний тайланг тус тус хавсаргав.

Хавсралт хуудастай.

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2016 он